



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/᠑᠐5

Булган сум

**Багийн эмч нарыг чадавхжуулах сургалт
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөөгийн багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэн ажилладаг багийн эмч нарыг чадавхжуулах сургалтын удирдамж, хөтөлбөрийг 1 дүгээр, сургалтад зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Багийн эмч нарыг чадавхжуулах сургалтыг нүүр ам судлалын “Энх Мөнх хөгжлийн төв”-тэй гэрээ байгуулан, үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т даалгасугай.

3. Дээрх сургалтад зарцуулагдах 19,995,200 (арван есөн сая есөн зуун ерэн таван мянга хоёр зуу) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010979


Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 30-ны/ний өдрийн
А/205 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**БАГИЙН ЭМЧ НАРЫГ ЧАДВАРЖУУЛАХ СУРГАЛТЫН
УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР**

Зорилго: Булган аймгийн багийн эмч нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх
Хамрах хүрээ: Булган аймгийн 46 багт ажиллаж байгаа эмч нарыг хамруулна.
Хэзээ: 2025 оны 11 дүгээр сарын 05-наас 07
Хаана: Улаанбаатар хот АШУҮИС-ийн төв байр

Хугацаа	Үйл ажиллагаа	Чиглүүлэгч
1	2	3
Эхний өдрийн		
12:00-18:00	Булган аймгаас Улаанбаатар хот руу зорчих	Зохион байгуулагч
18:00-19:00	Зочид буудалдаа байрлах	Зохион байгуулагч
19:00	Оройн хоол	Зохион байгуулагч
2 дахь өдөр		
07:50-08:30	Зочид буудлаас АШУҮИС-руу явах	Зохион байгуулагч
08:30-09:00	Сургалтын бүртгэл	Зохион байгуулагч
09:00-09:10	Нээлтийн үг	Аймгийн Засаг даргын зөвлөх Б.Батбаяр
09:10-10:50	Артерийн даралт ихсэлт	АШУҮИС-ийн АУС-ийн ӨАУТэнхимийн багш АУ-ны доктор Э.Хангай
10:50-11:00	Цайны завсарлага	
11:00-12:30	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл	АШУҮИС-ийн АУС-ийн ӨАУТэнхимийн багш АУ-ны доктор Э.Хангай
12:30-13:30	Өдрийн хоолны завсарлага	
13:30-15:00	Яаралтай тусламж үйлчилгээ	АШУҮИС-ийн МЯСЭ-ийн яаралтай тусламжийн тасгийн эмч О.Сайн-Ерөөлт
15:00-15:10	Цайны завсарлага	
15:10-16:40	Эх, нярайн тусламж үйлчилгээ	АШУҮИС-ийн СС-ийн ЭБЭХСТ-ийн ахлах багш АУ-ны магистр Б.Азжаргал
17:00-18:10	АШУҮИС-аас зочид буудалд зорчих	Зохион байгуулагч
18:30-22:00	Gala Dinner	Зохион байгуулагч
3 дахь өдрийн сургалт		
09:00-09:30	Бүртгэл	
09:30-10:30	Төрийн ордонтой танилцах	Зохион байгуулагч
10:30-12:30	Чингисийн музей үзэх /тайлбарлагчтай/	Зохион байгуулагч
13:30-14:30	Өдрийн хоол, хаалт	

Аймгийн Засаг даргын 2025 оны
 10. дугаар сарын 30-ны/ний өдрийн
 А/аос дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



БАГИЙН ЭМЧ НАРЫГ ЧАДВАРЖУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Оройн хоол	ш	42	25,000	1,050,000
2	Зочид буудал	ш	42	140,000	5,880,000
3	Автобусны түрээс	ш	1	250,000	250,000
4	Сургалт орох багшийн цалин	Хүн	4	300,000	1,200,000
5	Сургалтын цай	ш	84	9285	780,200
6	Сургалтын өдрийн хоол	ш	42	16,790	705,000
7	Кредитийн төлбөр	ш	42	50,000	2,100,000
8	Гала диннер	ш	47	85,000	3,995,000
9	Хөтлөгч	Хүн	1	300,000	300,000
10	Бүжгийн хувцас	ш	5	120,000	600,000
11	Дуучин	Хүн	2	100,000	200,000
12	Чингис хаан музей	Хүн	43	45,000	1,935,000
13	Музей тайлбарлагч	Хүн	1	100,000	100,000
14	Өдрийн хоол хаалт	ш	45	20,000	900,000
	Нийт				19,995,200

--ооо--